



МОНГОЛ
УЛСЫН
ЗАСАГ
ДАРГА
ТАМГЫН
ГАЗАР



СУМЫН ЗАСАГ ДАРГЫН “ДАШИНЧИЛЭНГИЙН ХӨГЖИЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Илтгэгч: Сумын Засаг дарга С.Мэнд-Амар



“ДАШИНЧИЛЭНГИЙН ХӨГЖИЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

“ХҮНИЙ ХӨГЖИЛ”-ийг дэмжсэн, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар “ЭДИЙН
ЗАСАГ”-ийг өсгөсөн, дэд бүтцийг хөгжүүлж “ОРОН НУТАГ”-таа ая тухтай, амар
тайван, аз жаргалтай амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино гэж
ТОДОРХОЙЛОВ.



“ДАШИНЧИЛЭНГИЙН ХӨГЖИЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БҮТЭЦ

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1. Эрүүл мэнд
2. Боловсрол
3. Гэр бүл, хүүхэд, залуучууд
4. Хөдөлмөр эрхлэлт
5. Нийгмийн хамгаалал, халамж
6. Биеийн тамир, спорт
7. Соёл, урлаг

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

1. Эдийн засгийн бодлого
2. Хүнс, Хөдөө аж ахуй
3. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай

ГУРАВ. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

1. Газрын харилцаа, барилга, дэд бүтэц
2. Үйлдвэрлэл үйлчилгээ

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

1. Хууль, эрх зүй, батлан хамгаалах
2. Цахим засаглал
3. Булган аймгийн түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх
4. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба



ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО



ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГО



БҮС ОРОН НУТГИЙН
ХӨГЖИЛ



ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.

1.1. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, сумын хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийн нэмэгдүүлэх замаар сумын хүн амын дундаж наслалтыг аймгийн зорилтот түвшинд хүргэнэ.




2025 оны эхний хагас жилийн байдлаар эрт илрүүлгийн хамрагдалт 29.5 хувьтай, элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 700 иргэн, элэгний В вирусын сайн дурын дархлаажуулалтад 17-73 насны 75 иргэн хамрагдсан байна. хамрагдсан байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 1 тохиолдож, нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ 0.3 хувьтай, Хорт хавдар өвчний шалтгаант нас баралт 1 тохиолдож, нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ 0.3 хувьтай байна. Тайлант хугацаанд эхийн эндэгдэл, нялхасын эндэгдэл, 5 хүртэлх хүүхдийн эндэгдэл гараагүй.





Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 1911 иргэнийг хамруулахаас 565 иргэд, Хүний папиллома вирусын вакцинд 11 насны 64 хүүхэд хамрагдахаас 52 хүүхдийг хамруулж, хамрагдалтын хувь 81.2% байна. Умайн хүзүүний хавдар илрүүлэх хиймэл оюун ухаанд суурилсан үзлэгт 78 иргэн, халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэг артерийн гипертензид 185, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 92, хөхний хорт хавдрын үзлэгт 70 эмэгтэйг тус тус хамруулсан.






Эрүүл мэнд, Боловсролын сайдын хамтарсан тушаалын хүрээнд "СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ"-ийг эхлүүлж, үзлэгт ЕБС-ийн сургуулийн 1 дүгээр ангийн сурагчид шүд, нүд, зүрх-ний эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж, эмчилгээг хийсэн.





Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй 13 арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүд, нэрэмжит сарын аянуудын хүрээнд хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 7665 иргэдэд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, цахим хаягаар зөвлөмж, мэдээллийг тухай бүрт хүргэн ажиллалаа.





Мөн хөдөө 3 багийн 82 өрхийн 161 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдол, улаан бурхан өвчнөөс сэргийлэх талаар сургалт хийн зөвлөмж тараасан.





Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 5.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих ажил хийгдэж, 2025 оны 09 дүгээр сард ашиглалтад өгөхөөр хүлээгдэж байна. Мөн Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд оношилгооны 40ш, лабораторийн 12ш, эмчилээний 29ш, ариутгал, угаалга, гал тогооны 15ш тоног төхөөрөмж болон бусад тавилга 19ш, бүгд 115ш тоног төхөөрөмж нийлүүлэхээр жагсаалтийг ирүүлсэн байна.





2025 оны 05 дугаар сард аймгийн ЭМГ-аас мобайл технологийн багц тоног төхөөрөмж /эхо аппарат, зүрхний цахилгаан бичлэг, сахарын аппарат, холестерин хэмжигч/-ийг шинээр олгосон.





ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулан 30.0 сая төгрөгний үнэ бүхий зөөврийн орон сууцыг хүлээлгэн өгсөн. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулж, шатахууны зардалд 625.0 мянган төгрөгийг зарцуулсан. Залуу 1 сувилагчийг УБ хотод 3 сарын мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургалтын төлбөрт төсвөөс 192.0 мянган төгрөгийг олгосон.





НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.


1.2. БОЛОВСРОЛ

Хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвөлсөн хүмүүнлэг ёс зүйтэй, өв тэгш иргэнийг төлөвшүүлнэ.



2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-ийн хамран сургалтын 100%, Цэцэрлэгийн хамран сургалт байнгын бүлэгт 86%, хувилбарт бүлэгт 4%, цэцэрлэгийн хэмжээнд нийт хүүхдийн хамран сургалт 90%-тай байна. Сумын хэмжээнд ЕБС болон СӨБ-ын насны ялгаатай хэрэгцээтэй 10 хүүхэд байгаагаас ЕБС болон цэцэглэгт 9 хүүхэд хамрагдаж байна.

ХАМРАН СУРГАЛТЫН ХУВЬ



ХАМРАН СУРГАЛТЫН ХУВЬ







ЕБС-ийн хичээлийн 1 дүгээр байранд 50 сая төгрөгийн өртөг бүхий урсгал засварын ажлыг эхлүүлээд байна. Улсын төсвийн 3.7 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн ортой дотуур байрны барилга баригдаж, хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны барилгыг нэгдсэн халаалтад холбох сантехникийн засварын ажлын тендер зарлагдаж, гэрээг байгуулаад байна. ЕБС-ийн дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын төсвийг Боловсролын яаманд уламжлсан.



Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 75 хүүхдийн хүчин чадалтай барилгын зураг төсвийг Аслаан ХХК-иар гүйцэтгүүлэн, 2026 оны улсын төсөвт тусгуулахаар холбогдох газарт уламжлаад байна.



ЕБС, цэцэрлэг, дотуур байрны тоног төхөөрөмжийн хангалт 80 хувьтай байна. ЕБС-д 80 сая төгрөгийн өртөг бүхий лингафоны танхим шинээр байгуулах ажил хийгдсэн. Албан хаагчдад шаардлагатай байгаа 3ш суурин компьютер, 4ш хромбүүк, 4ш нотебүүкийг 25,7 сая төгрөгөөр, биологийн хичээлийн дадлага ажилд ашиглах 2ш тасалгааны нарийн ногоо үрслүүлж тариалах төхөөрөмжийг 5 сая төгрөгөөр авч сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хэсэгт 1,9 сая төгрөгийн үнэ бүхий хөлдөөгчийг авсан.





Хүүхдийн цэцэрлэг нь 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар багш хөгжлийн тэнхимд ухаалаг дэлгэц, хэвлэгч, хувилагчийг худалдан авч, аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир Steam хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг цэцэрлэгт хүлээлгэн өгсөн байна.



ᠤᠯᠤᠰ ᠲᠦᠨ ᠶᠡᠭᠡᠢ ᠵᠣᠪᠴᠢᠳᠤ

Subject	Score
Англи хэл	485
Хими	528.1
Нийгэм судлал	451.8
Биологи	488
Математик	476.6
Физик	448.3
Монгол хэл	590.6
Нийт дундаж	495.5



ЕБС-ийн хэмжээнд “Хүмүүн бичиг”, Залуу байгальч, Юмханаар юм хийе, Залуу зохион бүтээгч зэрэг 12 төрийн дугуйлан хичээллэж, давхардсан тоогоор 100 гаруй сурагч хамрагдаж байна.





ЕБС-ийн багш, сурагчид 2024-2025 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан нэрэмжит болон төрөлжсөн олимпиадуудад амжилттай оролцож, Сансрын нисэгч Ж.Гүррагчаагийн нэрэмжит "САНСАР-44" хэлний XVI олимпиад Монгол хэлний төрөлд 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, Орос хэлний төрөлд 1 мөнгө, Англи хэлний төрөлд 1 хүрэл,





АБТА, ахмад багш Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит химийн 22 дугаар олимпиадад 2 мөнгө, 1 хүрэл, 1 тусгай байр, хамгийн олон шавь амжилттай бэлтгэсэн багшаар химийн багш Ц.Туул тус тус шалгарсан байна.



ᠤᠯᠤᠰ ᠲᠦᠨ ᠶᠡᠭᠡᠢ ᠵᠣᠪᠴᠢᠳᠤ



Улсын төрөлжсөн олимпиадын II давааны "Математик"
судлагдахууны төрлөөр амжилттай оролцлоо.

Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын давааны "МОНГОЛ
ХЭЛ, БИЧИГ" судлагдахууны 12-р ангийн төрөлд: 12а
ангийн сурагч Б. Отгондэлгэр 1-р байр, Б.Бат-Орших 3-р
байранд тус тус амжилттай оролцлоо.

УЛСЫН ТӨРӨЛЖСӨН
ОЛИМПИАДЫН II ДАВАА

Математик судлагдахуунаар:
8-р анги төрөлд:
86 ангийн сурагч Б. Одонтунгалаг "АЛТАН" медаль
/бэлтгэсэн багш А. Цэнджав/

5-р анги төрөлд:
56 ангийн сурагч О. Цэнд-Аюуш "МӨНГӨН" медаль
56 ангийн сурагч Б. Бүжинлхам "ХҮРЭЛ" медаль
56 ангийн сурагч С. Мөнххүлэг "ДӨРӨВДҮГЭЭР" байр
/бэлтгэсэн багш М. Өсөхжаргал/

Багш төрөлд:
М. Өсөхжаргал багш "ХҮРЭЛ" медаль

Багш, сурагчдадаа баяр хүргэе.





Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд дизайн технологийн багш Э. Дондог хүрэл медаль, Нисэх загварын төрөлд 10а ангийн сурагч Г.Доржбат хүрэл медалийг тус тус хүртсэн байна.





Монголын хүүхдийн спортын VIII-р наадмын "САМБО БӨХИЙН ТЭМЦЭЭН"-д Ж.Цогтбаатар багш дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож, 4 алт, 3 мөнгө, 6 хүрэл медалийн эзэн болж, багийн нийлбэр дүнгээр 1-р байр, Булган аймгийн классик пауэрлифтингийн 2025 оны аварга шалгаруулах, Монголын бүх ард түмний спортын наадмын сорилго тэмцээнд Ж.Цогтбаатар багштай баг тамирчид амжилттай оролцож, 4 алт, 14 мөнгө, 4 хүрэл медалийн эзэн болсон байна.





Шүд угаалтын “Аймгийн аварга шалгаруулах” тэмцээнд 18 багийн 144 сурагчид оролцсоноос багийн нийлбэр дүнгээр Дашинчилэн сумын “Эрдэнийн чулуунууд” баг дэд байр, ганцаарчилсан төрөлд Ж.Урангуа тэргүүн байр эзэлсэн байна.



የግንባታ ሥራ ላይ የሚሳተፉት ሰራተኛ





“Интеграцид суурилсан багшлахуй ба суралцахуй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын 2-р шатанд нийт 18 сургууль оролцсоноос Э.Дондог, Б. Мөнхсайхан багш нарын “Туршилтат арга зүйг интеграцлах нь” сэдэвт илтгэл 5-р байранд шалгарсан байна.







ЕБС-ийн багш, ажилчид Боловсролын яам болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 25 төрийн албан хаагч, ажлын байран дээрх сургалтад 35 төрийн албан хаагч, багшийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад давхардсан тоогоор 42 төрийн албан хаагч хамрагдсан байна.





Цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарын онол эрх зүйн болон мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор эрхлэгч, бүлгийн 5 багш, туслах 4 багш, тогооч нарыг улс, аймаг, бүсийн хэмжээнд зохион байгуулсан сургалтуудад 3-4 удаа хамруулж, сургалтын төлбөрт нийт 2013,1 мян/төгрөгийг зарцуулсан. Дотоодын туршлага судлах ажлын хүрээнд цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаа СӨБ-ын байгууллагуудын удирдах ажилтануудын хамт Дархан хотын цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай, арга зүйч О.Давааням аймгийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагч нарын хамт Орхон аймгийн 1,5,10 дугаар цэцэрэгийн үйл ажиллагаатай тус тус танилцсан. Мөн цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багш нарын 8 албан хаагч Булган аймгийн 7 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалан, сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.



Багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, сурагчдад зөв хүмүүжил төлөвшлийг бий болгох зорилго бүхий “ТАЛАРХЛЫН АЯН”-ны хүрээнд “Цэвэр цэмцгэр орчинд сурах нөхцлийг бүрдүүлж өгдөг үйлчлэгч нартаа талархлаа”, “Үргэлж амттай хоолоор үйлчилдэг тогооч нартаа талархлаа” аяныг зохион байгуулсан.



**Булган аймгийн Дашинчилэн
сумын ЕБС**

Apr 30 · 🌐


Сурагчдын нэг өдрийн Үдийн цайны хэсэг 🍌☕
🍏 Үргэлж амт сайтай, шим тэжээлтэй
хоолоор үйлчилдэг сургуулийн гал тогооныхоо
хамт олонд талархлаа 😊



**Булган аймгийн Дашинчилэн
сумын ЕБС**

May 2 · 🌐

Цэвэр цэмцгэр орчинд сурах нөхцлийг
бүрдүүлж өгдөг үйлчлэгч нартаа тал... **See more**





“Хүүхдээ сонсох өдөр”, эцэг эх, асран хамгаалагч нарыг хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцуулах, багш нараас зөвлөгөө авах ажил зэргийг зохион байгуулсан.





Мөн "Дэвтэр бол сурагчийн толь" сарын аян, Дашинчилэн сум дахь эрэн хайх аврах бүлгийн үйл ажиллагаатай танилцах, явган аялал, ИТХ-ын даргын санаачилгаар ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын сум орон нутгийнхаа үзэсгэлэнт түүхэн дурсгалт газрыг үзэх танин мэдэхүйн аялал зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.





НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.

1.3. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, сумын хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийн нэмэгдүүлэх замаар сумын хүн амын дундаж наслалтыг аймгийн зорилтот түвшинд хүргэнэ.



Хагас жилийн байдлаар гэр бүлийн боловсрол олгох сургалт 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 104 иргэн хамрагдсан. ГХЗУСАЗСЗ-тэй хамтран Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын сэтгэлзүйчийг суманд ажиллуулж, сэтгэлзүйн анхан шатны ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 8 хүүхэд, 26 насанд хүрэгчдэд өгч, эрсдэлт нөхцөл дэх айл, архины хамааралтай иргэдтэй уулзан явуулын үйлчилгээ үзүүлсэн.





ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Хүүхдэд ээлтэй орчин” сургалт, нөлөөллийн ажлыг ЭМТ, хэсгийн төлөөлөгч, ЕБСургууль, соёлын төвтэй хамтран зохион байгуулж, 74 хүүхэд, 6-12 дугаар ангийн сурагчдын дунд "Гэр бүлийн хүчирхийлэл", "Утаат болон электрон тамхины хор хөнөөл, үр дагавар", "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвээр 1 удаагийн сургалт, Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, 30 сурагч, 6-12 дугаар ангийн сурагчдын дунд "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, 14 сурагчийг тус тус хамруулсан.





ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчдад газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, "СУУ-НУУГД-ХҮЛЭЭ" дүрмийн дагуу дадлага сургуулилтыг хийсэн.





Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу сумын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Булган аймгийн урд бүсийн СӨБ-ын байгууллагуудын дунд “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЦАГААН ТОЛГОЙ” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Тус нөлөөллийн арга хэмжээнд Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумын СӨБ-ын 40 хүүхэд, 8 багш, 16 эцэг эхийн төлөөлөл оролцсон.







Залуучуудын дунд 3 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 178 залуучууд, 5 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 624 иргэнийг хамруулан, 3,994,500 төгрөг зарцуулсан байна. Олон улс болон аймгийн чанартай 2 удаагийн уралдаан тэмцээнд оролцсон 7 залууст 630,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 12 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, сумын нийт залуучуудын 59 хувийг хамруулсан байна.





Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур, Булган сумын ахмадуудын дунд "ДУРСАМЖ УУЛЗАЛТ 2025" нөхөрсөг спортын тэмцээн болон дуун цэнгүүн зохион байгуулагдаж, нийт 77 ахмад, Рашаант суманд зохион байгуулагдсан “Дашинчилэн-Рашаант сумын ахмадууд – бид үе тэнгийнхэн” спортын нөхөрсөг уулзалт тэмцээнд 14 ахмад тус тус хамрагдаж, тэмцээний шагналын зардалд 650,000 төгрөг, бооцооны мөнгө болон шатахууны зардалд 375,000 төгрөгийг тус тус зарцуулсан. Сар болгон ахмадын дуун цэнгүүн, софт волейболын тэмцээн зохион байгуулагдаж, хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 511 ахмад хамрагдсан байна.





Сумын хамтарсан багийн гишүүдийг аймгийн ГХГБХХГ, МИГ даатгалтай хамтран зохион байгуулсан “Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах” сургалтад хамруулсан. Хамтарсан багийн тайланг хагас жилийн байдлаар 2 удаа аймгийн ГХГБХХГ-т хүргүүлсэн. 2025 оны хагас жилийн байдлаар Хүүхэд хамгааллын зардалд 27,000 төгрөг, хүүхдийн хөгжлийн чиглэлээр 738,600 төгрөг, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр 77,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус зарцуулсан байна.





НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.

1.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлыг байрыг бий болгож, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

[illegible]

Өрхийн судалгаа



A 3D pie chart illustrating the frequency of internet usage. The chart is divided into two segments: a large blue segment representing 'Often' with a value of 813, and a smaller red segment representing 'Not often' with a value of 102. The chart is viewed from an angle, giving it a three-dimensional appearance.

Frequency	Count
Often	813
Not often	102

■ Бусад ■ АБТДО




“Халамжаас-Хөдөлмөрт” зорилтын хүрээнд 2025-2028 онд хөгжүүлэх “Зөв-20” өрхийг сонгон, дээрх өрхүүдээс 5 иргэнийг төсөл бичих сургалтад, 8 иргэнийг хөдөлмөр эрхлэх сургалтад хамруулж, 5 иргэнийг байнгын ажлын байранд буюу эрэн хайх аврах бүлэгт 1 иргэн, ЭМТ-д 1 иргэн, цэцэрлэгт 1 иргэн, хувийн хэвшилд 2 иргэнийг зуучилсан байна. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 2 өрхийг малжуулах төсөл хөтөлбөрт, 5 өрхийг "Шинэ хоршоо" хөдөлгөөнд хамруулсан байна.





Хагас жилийн байдлаар шинээр байнгын ажлын байранд 30, улирлын ажлын байранд 1, түр ажлын байранд 1, нийт 32 ажлын байр бүртгэсэн байна. Мэргэшсэн мэргэжил сургалтын төвөөс ажил хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны 32 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн 12-р ангийн 27 сурагч, 7-11-р ангийн 70 сурагч хамрагдсан байна.

Зуучилсан ажлын байрны тоо



■ Байнгын ажлын байр ■ Улирлын ажлын байр ■ Түр ажлын байр





ХЭДС-аас зарлагдсан малжуулах төсөл хөтөлбөрт 4 өрх хамрагдаж, 32 сая төгрөг, ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж, 32 сая төгрөг, иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж, 10 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж, 16 сая төгрөгийн зээлийг тус тус авсан байна.





НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.

1.6. БИЕИЙН ТАМИР

Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжинэ.



Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх идэвхийг өрнүүлж, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд 50 сая төгрөгийн өртөг бүхий фитнесийн тоног төхөөржийг худалдан авч, суурилуулах ажил хийгдэж, үйл ажиллагаа жигдэрсэн байна. ЕБС-ийн спорт талбайг хашаажуулах ажлыг ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэхээр хашааг татан авсан.



[illegible]



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар өрнөж буй Эрүүл Монгол хүн хөдөлгөөний хүрээнд “Идэвхтэй алхалтад-Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг 2025.05.15-аас 2025.06.20-ны хооронд зохион байгуулж, аяны хүрээнд Дашинчилэн марафон 2025, өглөөний алхалт зэрэг арга хэмжээнд 707 иргэн хамрагдаж, 2,191,500 төгрөг зарцуулсан байна.





Монголын хүүхдийн спортын VIII-р наадмын "САМБО БӨХИЙН ТЭМЦЭЭН"-д ЕБС-ийн Ж. Цогтбаатар багш дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож, 4 алт, 3 мөнгө, 6 хүрэл медалийн эзэн болж, багийн нийлбэр дүнгээр 1-р байр, Булган аймгийн классик пауэрлифтингийн 2025 оны аварга шалгаруулах, Монголын бүх ард түмний спортын наадмын сорилго тэмцээнд 4 алт, 14 мөнгө, 4 хүрэл медалийн эзэн болсон байна.





"Хойд бүсийн лиг 2025" шагай харвааны тэмцээнд амжилттай оролцож, багийн дүнгээр 2 дугаар байр эзэлсэн. Булган аймагт зохион байгуулсан "Иргэдийн спортын наадам"-ын 2 дугаар шатны шалгаруулалтад "Чинтолгой" бүсийн волейболын 45+ насны эмэгтэй баг тэргүүн байр эзэлсэн. Улс, аймаг, бүсийн чанартай 6 тэмцээн уралдаанд оролцсон 28 хүнд 1,660,000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна.





НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийг хөгжих, суралцах, ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, эрдэм боловсролтой, эрүүл, нийгмийн идэвхтэй иргэнийг хөгжүүлнэ.

1.7. СОЁЛ УРЛАГ

Үндэсний өв соёлоо хамгаалсан, эх оронч үзэлтэй иргэнийг төлөвшүүлж, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын дархлааг бэхжүүлнэ.



2025 оны эхний хагас жилийн байдлаар 11 удаагийн урлагийн тоглолт, 5 удаагийн дуун цэнгүүн, 3 удаагийн тэмцээн уралдаан, 4 удаагийн цэнгээнт бүжгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 1950 иргэнийг хамруулсан байна.



*Тэрэлт ирээдүйн зүг
халтдаа -2*

*М.Осохжаргал багштай 5᠔ ангийн
сурагчид, эцэг эх, асран
халгаалагчдын халтарсан
тоглолтонд та бүхнийг хүрэлцэн
ирэхийг урьж байна.*

*Хэзээ: 2025 оны 4 сарын 28 ны
Даваа гарагт.*

*Тайх: Хүүхэд 3000₮ — 15:00 цагаас
Товч хүн 5000₮ — 19:00 цагаас*





"Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд 2025" хаврын 37 дахь удаагийн үйл ажиллагааны хүрээнд "Үсэглэлийн хаад", "Та та тунга" тэмцээн, "Үлгэрээс үлгэрлэе" номын үзэсгэлэн, зөөврийн номын сан", "Үндэсний бичиг үсгийн өдрүүд 2025", "Үндэсний бичгийн хурдан уншлага"-ын тэмцээнийг тус тус зохион байгуулсан байна.



"ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД 2025" хаврын 37 дахь удаагийн үйл ажиллагааны хөтөлбөр

15:00-15:15	Нээлтийн үйл ажиллагаа
15:15-16:00	"Үсэглэлийн хаад" 6-9 дугаар анги
16:00- 17:00	"ТаТа Тунгаа" хөгжөөнт уралдаан

"Үлгэрээс үлгэрлэе" цэцэрлэгийн насныханд
Номын үзэсгэлэн
Зөөврийн номын сан

Тэмцээн: 2025 оны 05 сарын 20-нд 15 цагаас Соёлын төвд болно.



ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ЦЭВЭР САЙХАН БИЧИХ УРАЛДААН

**БИЧИХ СЭДЭВ: ЧӨЛӨӨТЭЙ
ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- А4 ЦААСАН ДЭЭР ХАРАНДААГААР ШУГАМ ТАТАЖ БИЧСЭН БАЙХ
- 100 ҮГЭЭС ДООШГҮЙ БАЙХ
- ЗӨВ, ЦЭВЭР БИЧСЭН БАЙХ
- ОВОГ НЭР УТАСНЫ ДУГААР БИЧИХ

ХАМРАХ ХҮРЭЭ: БҮХ НАСНЫХАН ОРОЛЦОХ
БОЛОМЖТОЙ НАСНЫ ХЯЗГААРГҮЙ




ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Тэргүүн байр-Өргөмжлөл 50,000 төгрөг
Дэд байр- Өргөмжлөл 30,000 төгрөг
Гутгаар байр- 20,000 төгрөг

ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

2025 ОНЫ 05 САРЫН 02-НЫ 18:00 ЦАГ
ХҮРТЭЛ СОЁЛЫН ТӨВИЙН НОМЫН
САНД ХҮЛЭЭН АВНА.





ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн бүтцийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээгээ хангаж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхийг зорино.


2.1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн өсөлтийг дэмжин, үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялагийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.



Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 2025 оны 6 дугаар сарын байдлаар 392.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 297.3 сая төгрөг төвлөрч, 75.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2025 оны 6 сарын гүйцэтгэл /сая төг/





БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМАНД 2025 ОНД УЛСЫН
ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг			2025 онд санхүүжих дүн
					Анхны	Сүүлийн	2025 онд	
XVIII.1.26	Хүүхдийн тоглоомын талбай /Булган, Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сум/	УТ2402901677	2024	2026	1,700.0	1,700.0	1,679.4	629.4
XVIII.1.9	Гадна инженерийн шугам сүлжээ /Булган, Дашинчилэн сум/	УТ2402901676	2024	2026	2,680.8	2,680.8	2,678.4	1,088.0

БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМАНД 2025 ОНД ОРОН НУТГИЙН
ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	2025 онд санхүүжих дүн (мян.төг)
1	Ковш худалдан авах	2025	2025	185,000.0	185,000.0
2	Ерөнхий боловсролын сургуулийн сантехник засвар	2024	2025	30,000.0	30,000.0
3	Тарвага сэргээн нутагшуулах	2024	2025	18,000.0	9,000.0
4	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилтийн элсний нүүдлээс хамгаалах зурвасын ажил	2024	2025	45,000.0	6,600.0



“Хойд бүсийн зөвлөл” анхдугаар хуралдааны хүрээнд “Хойд бүсийн хоршоологчдын зөвлөгөөн”, “ТҮНШЛЭЛ-ХАМТЫН АЖИЛЛАГАА” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, тус үзэсгэлэн худалдаанд 2 ААН, 3 хоршоо, 9 иргэн чацарганы өтгөрүүлсэн шүүс, чацарганы шимт ааруул, Өрхтий гурил, Монгол үндэсний хувцас, гутал, арьсан эдлэл, хутга зэрэг бүтээгдэхүүнээр оролцсон. “Амар байна уу-2025” сар шинийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 2 хоршоо, 4 ААН, 4 жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид “Сүү, цагаан идээ”, “Чацаргана”, “Дээл”, “Гутал”, ахуйн бараа, бүтээгдэхүүний төрлөөр оролцож, 2.9 сая төгрөгийн борлуулт хийсэн.





ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн бүтцийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээгээ хангаж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхийг зорино.


2.2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулж, байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, тогтвортой үйлдвэрлэлтэй сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.




Сумын хэмжээнд өндөр ашиг шимтэй 41,560 мянган толгой мал буюу сүрэгт эзлэх хувийг 24,2-д хүрч өмнөх оноос 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Малын тоо толгойн харьцуулалт



■ Ашиг шимтэй мал ■ Бусад

Малын тоо толгойн харьцуулалт



■ Ашиг шимтэй мал ■ Бусад



Бэлчээрийн талбайг усжуулах ажлын хүрээнд Хараат багийн “Сувараа” гэх газарт шинээр 1 худаг гаргуулах хүсэлтийг аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Мөн Хараат багийн “Багийн төвийн худаг”, Лах багийн “Гурван цохионы худаг”, Доргонт багийн “Хэвтээгийн сайрмагийн худаг”-ийг засварлах ажлыг ОНХС-ийн 8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж гүйцэтгэсэн.





ХАА-н салбарын хүний нөөцийг бэхжүүлэх ажлын хүрээнд “ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 56 хоршооны 150 малчин, малын генетик нөөцийг судлан хөгжүүлэх, төлөвлөх, тайлагнах, ур чадвар олгох мэргэшүүлэх сургалтад Мал зүйчийг хамруулж, сургалтын төлбөрт 280 мянган төгрөгийг төлсөн. "Цагаан алт" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэд техник, төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, түүхий эдийн бэлтгэлийн чанарыг сайжруулах зорилготой "Алтан хайч-2025" хонь ноослох Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 иргэнийг хамруулсан.





2025 онд мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх 5 нэгжтэй гэрээ байгуулсан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Дотрын халдварт хордлого өвчний дархлаажуулалтад 12880, боом өвчний дархлаажуулалтад 400, шөвөг яр өвчний дархлаажуулалтад 1500, нийт 14780 толгой малыг хамруулсан байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.





2025 онд "Өрхтий хишиг" ХХК нийт 1670 га эргэлтийн талбайтайгаас 858 га-д улаанбуудай, 780 га-д рапс, 10 га-д овьёос, нийт 1648 га талбайд тариалалт хийж, нийт талбайнхаа 98.7 хувь буюу 2025 онд нэмж 448 га талбайг эргэлтэд оруулсан байна. "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөрийн хүрээнд "ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ" ХХК-аас 11 иргэн 4*8 харьцаатай, 32м2 хэмжээтэй, 2,470,000 төгрөгийн үнэ бүхий хүлэмжийг 4 жил хувааж төлөх нөхцөлтэйгээр авсан.





ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн бүтцийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээгээ хангаж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхийг зорино.

2.1. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙ:

Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалан, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Улсын тусгай хамгаалалтад 20026.35 га, орон нутгийн тусгай хамгаалалтад 129220.79 га буюу нийт газар нутгийн 64.3 хувийг тусгай хамгаалалтад авсан байна.



Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны хаврын тариалалтаар 1235ш мод тарьж, төлөвлөгөөний хэрэгжилт 15.4 хувьтай байна. Бэлчээрийн төлөв байдлын судалгаа хийлгэхээр сумын ИТХ-аас ОНХС-аар 2025 оны төсвийн жилд “Мал аж ахуйн бэлчээрийн менежмент сайжруулах” арга хэмжээнд 11,000,000 төгрөг тусгагдаж, “БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, СУДЛАХ ОЛОН УЛСЫН СУДАЛГААНЫ ТӨВ” НҮТББ-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.





Сумын ОНХС-ийн 138 сая төгрөгний хөрөнгөөр "Хүн амын ундны усан хангамжийг сайжруулах" ажлын хүрээнд "Баясах ус эрдэнэ" ХХК сумын төвд шинээр 1 худаг гаргах, хуучин 1 цооног болон шинэ худагт цэвэршүүлэгч төхөөрөмж, ухаалаг худгийн системийг суурилуулах ажил хийгдэж байна.






“Цэвэр орчин цэмцгэр Булган” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулсан. Сумын ОНХС-ийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын нэгдсэн хогийг дарж булшлах ажил хийгдсэн. Мөнх ОНХС-ийн 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын тендер зарлагдаж, гэрээг байгуулаад байна.





Лах багийн малчин Г.Шижирбаатарын гэр бүл “Аялал жуулчлал”-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, “Nomad planet” ХХК-тай гэрээ байгуулан, жилд 200 гаруй жуулчдыг хүлээн авч, морин үзүүлбэр үзүүлэх, малчдын ахуй соёлыг сурталчлан ажиллаж байна.





Булган аймагт орон нутгийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зочид буудал, жуулчны бааз, зоогийн газрын удирдлага, ажилчдын мэргэшлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд “Зочлох үйлчилгээний ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалт” зохион байгуулагдаж, сургалтад 3 ААН-ийн 4 албан хаагч оролцсон.





ГУРАВ. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Эдийн засгийн бүтцийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээгээ хангаж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхийг зорино.

3.1. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ДЭД БҮТЭЦ

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу газар олголтыг хийх, дэд бүтцийг нэмэгдүүлэх, орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэд ажилтай, орлоготой, орлогодоо сэтгэл ханамжтай, орон нутагтаа тогтвортой, тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.


3.2. ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Нөөцийн давуу талд түшиглэсэн орон нутгийн онцлогтой бизнесийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.



2025 он газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 32 нэгж талбарыг өмчлүүлж, эзэмшүүлэхээр төлөвлөгдөж, 2025 оны хагас жилийн байдлаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 46.9 хувьтай байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт





Сумын хэмжээнд 5 төрийн байгууллага, 13 аж ахуй нэгж, 21 айл өрх нэгдсэн дулаан хангамжинд холбогдсон байна. 2024-2026 оны улсын төсвийн 2.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Гадна инженерийн шугам, сүлжээний ажил" хийгдэж байна. 2024-2025 онд цэвэр усны худаг гаргах болон цэвэр усны шугам сүлжээг шинээр тавих ажил хийгдэж, 2026 онд цэвэрлэх байгууламжийг барих төлөвлөгөөтэй ажиллаж байна.





ОНХС-ийн хөрөнгөөр 8 айлын орон сууцны барилга, хүндэтгэлийн өргөө, цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийг “ММ архитектур” ХХК-иар хийлгэж байна. ОНХС-ийн 75 сая төгрөгийн хөрөнгөөр 50ш нарны эрчим хүчээр тэжээгддэг гэрэл, 2ш цамхаган гэрэлтүүлэгийг суурьлуулах ажил хийгдсэн.




A photograph of a Sumch Arrower Mongolian Knife in its presentation box. The box is open, revealing the knife with a dark, patterned handle and a silver-colored blade. A small, light-colored object, possibly a bone or wood, is also visible in the box. The lid of the box features a large, stylized black character and several smaller characters in a script. A certificate of authenticity is placed in front of the box, detailing the knife's limited style, traditional Mongolian blacksmith methods, and modern composition and craftsmanship. The certificate also includes a red stamp and a signature.





БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хотод сүү цагаан идээг шинэ аргаар боловсруулах сургалт, аялалд 5 эмэгтэйг оролцуулж, туршлага судлуулсан байна. “Зочлох үйлчилгээний ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалт” -д 3 ААН-ийн 4 иргэн, Булган аймагт зохион байгуулагдсан Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэгт 3 ЖДҮ эрхлэгчийн төлөөллийг тус тус хамруулсан.



БНХАУ-ЫН ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ЭРЭЭН ХОТОД ХИЙХ СҮҮ ЦАГААН ИДЭЭГ ШИНЭ АРГААР БОЛОВСРУУЛАХ СУРГАЛТ, АЯЛАЛЫН ТАНИЛЦУУЛГА

Зорилго:

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг дэвшилтэт технологийн тусламжтайгаар боловсруулах аргад суралцах, ажлаа хөгжөөчлөх, ажлын байр шинээр бий болгох, орлогоо нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох, худалдааны эргэлтийг сайжруулах, хувь хүний хөгжил, хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэхэд сургалт, аялалын зорилго чиглэгдэнэ.

Зохион байгуулагчид

- Эко Дэлгэрэх ХХК-ын Захирал Д. Дэлгэрмаа 99994465
- Орон нутгийн хөгжил, шинэчлэлийн төвийн Захирал М. Ариунболд 99562041
- Эрээн хотын Эмэгтэйчүүдийн холбоо
- Өвөр монголын өөртөө засах орны орны дэсийн цагаан идээний уламжлагч
- О. Нарантунгалаг, Шилийн гол аймгийн Цагаан идээний сургагч багш Чимэдүү оролцоно.

Сургалт, аялалын хөтөлбөр

Эхний өдөр

- 16:00 Улаанбаатар галт тэрэгний буудал дээр цуглах
- 16:40 Улаанбаатар хотоос хөдлөх

Хоёр дах өдөр

- 07:30 Замын Үүд өртөөнд бууна
- 08:00 Замын Үүд-Эрээний автобусанд сууна
- 11:00 Эрээн хотод ирнэ
- 12:00 Малчин, цагаан идээ боловсруулагч О.Нарантунгалагийн очино.
- 12:30 Өдрийн хоол
- 13:00 Цагаан идээ боловсруулах сургалт /Уламжлалт цагаан идээг шинэчлэн бэлтгэх аргад суралцах бөгөөд 1 өдрийн сургалтаар 5-7 төрлийн бүтээгдэхүүн хийхийг заана. Үүнд: Сүүн хурууд, эзгий, шар сүүний чихэр, тараг бүрэх, жимстэй өрөм, жимстэй хурууд хийх зэрэг технологи, аргачлал орно. Мөн тоног төхөөрөмжтэй ажиллах болон багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад зуучилна!

- 18:00 Оройн хоол
- 19:00 Буудалдаа байрлах
- 22:00 Амрах

Гурав дах өдөр

- 08:00 Өглөөний цай
- 11:00 Зах, худалдааны төвүүдээр аялах
- 18:00 Буудалдаа амрах

Дөрөв дэх өдөр

- 08:00 Өглөөний цай
- 10:00 Зах, худалдааны төвүүдээр аялах
- 14:00 Эрээн хотоос хөдлөх
- 17:00 Замын Үүд өртөөнд дээр ирэх
- 18:00 Улаанбаатар хотруу хөдлөх

Сургалт, аялалын төлбөр-750 000 төгрөг /Багшийн цалин, сургалтын материал хэрэглэгдэхүүн, багаж тоног төхөөрөмж, хоол, буудал, ирж очих зардал/

- ХААН банк 5277014104 Дашдаваа Дэлгэрмаа дансанд урьдчилга 250 000 төгрөг шилжүүлсэнээр бүртгэл баталгаажна.



ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, хүний эрхийг дээдэлсэн, төрийн үйлчилгээг үзүүлж, үндэсний эв нэгдэл, хуулиа дээдэлсэн иргэдтэй, аюулгүй, амар тайван орчныг бүрдүүлнэ.

4.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМААЛАХ

Иргэд амар тайван, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлж, эх орноо батлан хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулна.

4.2. ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, ил тод, хүртээмжтэйгээр хүргэнэ.

4.4. МЭРГЭШСЭН, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА

Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.



Иргэд, хүүхэд багачуудын дунд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр "Цагаан толгой" урд бүсийн тэмцээн, Хүүхэд сурагчдын дунд "Архи тамхи, дэлгэцийн донтолт", "мотоцикль", "Үе тэнгийн дээрэлхэлт" зэрэг сэдвийн хүрээнд сургалт, дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.





ГХЗУСАЗСЗ-тэй хамтран Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын газрын сэтгэлзүйчийг суманд ажиллуулж, сэтгэлзүйн анхан шатны ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 8 хүүхэд, 26 насанд хүрэгчдэд өгч, эрсдэлт нөхцөл дэх айл, архины хамааралтай иргэдтэй уулзан явуулын үйлчилгээ үзүүлсэн.





ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн байрыг хашаажуулах ажил, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 6 сая төгрөгийг төсөвлөсөн. "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2025" нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус суманд хуваарилагдан ажиллаж буй цагдаагийн алба хаагчдын хоолны зардалд 600 мянган төгрөгийг олгосон.





Аймгийн ОБГ-с Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг шалгалт, сургалт 2025.05.07-ны өдөр зохион байгуулж, сумын Онцгой комисс, Шуурхай штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн бэлэн байдал 83.2 хувьтай дүгнэгдсэн. Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авах ажлын хүрээнд газар хөдлөлтийн бэлэн байдал, осол гэмтэл, галын аюулгүй байдлаас сэргийлэх нь, сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 460 иргэнийг хамруулсан. Онцгой комиссын шуурхай штабыг шинэчлэн байгуулж, шуурхай штабын бие бүрэлдэхүүнд “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ын сургалтыг зохион байгуулсан.





Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Монгол цэргийн өдрийг угтан Хараат багтай хамтран багуудын дунд хүчит бөхийн барилдаан, ЕБС-ийн 10, 11, 12-р ангийн эрэгтэй сурагчдад цэрэг эх оронч үзэл олгох, Монгол улсын Батлан хамгаалахын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулийн сургалтыг тус тус зохион байгуулж, сурагчдын дунд танин мэдэхүйн, хөгжөөнт АХА тэмцээнийг зохион байгуулсан. Хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг эрсийн ар гэрт талархлын захидал илгээж, хүндэтгэл үзүүлж, цэргийн алба хааж байгаа цэрэг эрсийн алдар гавъяаг цахим орчноор сурталчлах ажлыг зохион байгуулав.





Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор "Хурдан" системийг нэвтрүүлж, 24-н цагийн ажиллагаатай КИОСК машиныг ажиллуулж байна. Эхний хагас жилийн байдлаар E-mongolia цахим системээс лавлагаа тодорхойлолтыг 450 гаруй иргэнд, КИОСК машинаас давхардсан тоогоор 100 гаран иргэн лавлагаа тодорхойлолт авсан байна. Dashinchilen.bu.gov.mn сайтыг шинэчлэж, сайтаар иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, боломжийг бүрдүүлсэн. Мөн иргэд, олон нийтийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг цаг алдалгүй 7034-6634 дугаарын нээлттэй утсыг ажиллуулж байна.

БУЛГАН АЙМГИЙН ДАШИНЧИЛЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

7034-6634



- ✓ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
- ✓ САНАЛ, ХҮСЭЛТ
- ✓ WWW.DASHINCHILEN.BU.GOV.MN

ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС САНАЛ, ХҮСЭЛТ,
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
АЖЛЫН ӨДРҮҮДЭД 09:00-18:00
ЦАХИМ ХАЯГ 24/7

Dashinchilen.bu.gov.mn





Төрийн албан хаагчдын дунд мэдлэг олгох, хууль эрх зүйн сургалтыг нийт давхардсан тоогоор 6 удаа 13 сэдвийн хүрээнд 146 төрийн албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.





Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд ЗДТГ-ын барилгын 2 давхар болон өргөтгөлийн коридор засвар, иргэний танхимын засвар, тамгын газрын гадна хаягжуулалт, иргэний танхимын хаягжуулалт хийх ажлыг байгууллагын төсвийн 35,4 сая төгрөгийн хөрөнгөөр, Лах багийн төвийн засварын ажлыг ОНХС-ийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэн, хүлээн аваад байна.






ИТХ нь проектор, хурдан сканнер, зөөврийн компьютер авахад 3.5 сая төгрөг, ЗДТГ албан хаагчдын компьютер, техник хэрэгслийг шинэчлэхэд 23,3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Засаг даргын орлогч, ХЭЗАХМ-ний компьютерийг шинэчлэх, архив, бичиг хэргийн эрхлэгчид хурдан сканнер, хэвлэл мэдээллийн ажилтанд дрон, видео бичлэгийн төхөөрөмж, зургийн аппарат зэргийг худалдан авч, хүлээлгэн өгсөн байна.





“ДАШИНЧИЛЭНГИЙН ХӨГЖИЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ





ТА БҮХНИЙ ХУРАЛДААНД АМЖИЛТ ХҮСЬЕ.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.